



БАЯНХОНГОР АЙМГИЙН
БАЯНХОНГОР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

74

2023 оны 02 сарын 15 өдөр

Дугаар A/40

Номгон

Хурдан морины уралдааныг хориглох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Монгол Улсын Үндсэн хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.2, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2, Зөрчлийн тухай хуулийн 6.20 дугаар зүйлийн 3.3, Засгийн газрын 2019 оны 57 дугаар тогтоол, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2022 оны А/122 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Баянхонгор сумын нутаг дэвсгэрт уяачид хэсэг бүлгээрээ нийлж хурдан морины үсэргээ, сунгаа хийх, бооцоот болон товлолт уралдаан зохион байгуулж болзошгүй нөхцөл байдлыг харгалзан унаач хүүхдийн эрүүл, аюулгүй байдлыг хангах зорилгоор 2023 оны 05 дугаар сарын 01-ний өдрийг хүртэл хурдан морины уралдаан зохион байгуулахыг хориглосугай.

2. Хориглосон хугацаанд ямар нэгэн уралдаан, сунгаа, үсэргээ хийлгэхгүй байхад хариуцлагатай хандаж ажиллахыг багийн Засаг дарга наарт үүрэг болгосугай.

3. Хурдан морины үсэргээ, сунгаа хийсэн, бооцоот болон товлолт уралдаан зохион байгуулсан иргэн, аж ахуйн нэгжид холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага тооцож ажиллахыг Цагдаагийн газрын Нийтийн хэв журмыг хамгаалах тасгийн дарга, Цагдаагийн дэд хурандаа (Б.Мөнгөнтулга)-д даалгасугай.

4. Хурдан морины уралдааныг хориглосон талаар уяачид болон иргэд, олон нийтэд мэдээлэх, сурталчлах ажилд хариуцлагатай хандаж ажиллахыг Хэвлэл мэдээлэл, олон нийт хариуцсан ажилтан (Д.Огонтунгалаг), орон нутгийн телевизийн захирал наарт үүрэг болгосугай.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Орлогч (С.Батцэрэн)-д даалгасугай.

ДАРГА Г.ЭНХБАЯР

Захирамж 2023

621010879